

БАТЛАВ
ХАН-УУЛ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА
С.ЭНХБАЯР
2024 оны 04 дүгээр сарын 09 өдөр

СОНГУУЛИЙН СУРТАЛЧИЛГААНЫ НЭГДСЭН САМБАР БАЙРШУУЛАХ
АЖЛЫН ЗУРГИЙН ДААЛГАВАР

2024 оны 04 дүгээр сарын 09

Улаанбаатар хот

1.	Төсөл боловсруулах үндэслэл	- Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль.
2.	Байршил, эдэлбэр газрын хэмжээ	- Хан-Уул дүүргийн нутаг дэвсгэрт 1-25 дугаар хороонд
3.	Байршуулах самбарын тоо	- 99 ширхэг нэгдсэн самбар /нэг нэгдсэн самбарт тухайн 3 мандат бүхий тойрогт нэр дэвшигчээр бүртгэгдсэн нийт нэр дэвшигчдийн АЗ хэмжээтэй зурагт хуудсыг Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1.2-т заасан дарааллаар байрлуулах боломжтой байхаар төлөвлөх бөгөөд 1 ширхэг нэгдсэн самбар нь зургийн даалгаврын хавсралтад заасан 3 ширхэг жишиг загварын самбараас багагүй байна./
4.	Самбарын загвар, хийцлэл.	- Самбарын 1 талд нь нэр дэвшигчдийн мэдээлэл байршуулах боломжтой байх. - Зөөвөрлөн шилжүүлж дахин ашиглах боломжтойгоор төлөвлөх. - Самбарын хүрээний хийцлэлийн хувьд төмөр рам түүнтэй адилтгах чанартай материалаар төлөвлөх. - Үндсэн самбарыг циллойд, цутгалтын хар фанер, өнгөлгөөний хавтан төмөр эсхүл түүнтэй дүйцэхүйц материалаар хийж нэр дэвшигчдийн АЗ хэмжээ бүхий зурагт хуудсыг байрлуулахад салхи, борооноос хамгаалагдсан байхаар төлөвлөх. - Барилгын хөгжлийн төвөөс тоймлон гаргасан сонгуулийн сурталчилгааны самбарын зураг төсвийг ашиглан нарийвчилсан ажлын зураг төсөл боловсруулах. - Дээрх үйл ажиллагаанд Монгол Улсын Сонгуулийн ерөнхий хорооны 2024 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн 1/187 дугаар албан бичгээр ирүүлсэн зөвлөмжийг баримтлахаас гадна тухайн тойрогт хэдэн нэр дэвшигч бүртгэгдэхээс шалтгаалж захиалагчтай зөвшилцөн залгаа байдлаар хийх самбарын тоог тогтоно.
5.	Төсөл гүйцэтгэх хугацаа	- Захиалагч, гүйцэтгэгч талуудын хооронд байгуулсан гэрээнд заасан хугацааг үндэслэл болгоно.
6.	Төслийн захиалагч	- Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газар
7.	Төсөл боловсруулахад ашиглах материал	<u>Хууль тогтоомжууд:</u> - Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хууль - Хот байгуулалтын тухай хууль, Хог хаягдлын тухай хууль - Бусад хуулиуд <u>Норм, нормативууд:</u> - Барилга захиалагчийн дүрэм - Ачаалал ба үйлчлэл /БНБД 20-04-17/ - Барилгын төсөв зохион дүрэм /БНБД 81-95-12/ - Бусад холбогдох норм, дүрэм <u>Стандартууд:</u> - "Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа. Эрүүл ахуй. Ажлын байрны орчин, эрүүл ахуйн шаардлага" MNS 4990:2000 - Хотын стандартын UCS1202B:2022 стандартыг мөрдөх.
8.	Эдийн засгийн тооцоо, төсөв	- Эдийн засгийн тооцоо болон төсвийг БНБД 81-95-12 болон эрх бүхий байгууллагаас зөвшөөрсөн программаар тооцох.
9.	Онцгой нөхцөл	- Тохижилтын стандарт мөрдөн төлөвлөх. - Хотын стандартын удирдамж, арга зүйн баримт бичиг мөрдөх.

ХЯНАСАН: ТӨЛӨВЛӨЛТ, ГҮЙЦЭТГЭЛИЙН УДИРДЛАГЫН
ХЭЛТСИЙН ДАРГА


Л.ОТГОНБАЯР

ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ХЭЛТСИЙН ДАРГА



Ч.БАЙГАЛЬ

БОЛОВСРУУЛСАН: ТӨЛӨВЛӨЛТ ГҮЙЦЭТГЭЛИЙН УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН
МЭРГЭЖИЛТЭН



О.МӨНГӨНШАГАЙ

ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН

Б.ОЧИР